

Сангийн сайдын 2013 оны 05 дугаар
сарын 31-ний өдрийн 125 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон.
**ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
БОДЛОГЫН ГАЗАР**

Улаанбаатар
2013 он

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: www.e-procurement.mn

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Гэрээний нэр: “Жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгсэл” нийлүүлэх

Дугаар: **БНДЭМТ/201907/02**

Улаанбаатар хот, Багануур дүүрэг
2019.07.17

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Багануур дүүргийн эрүүл мэндийн төв эрх бүхий тендерт оролцогчдоос “Жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгсэл” нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Багц 1: Жирэмслэхээс сэргийлэх суулгац нийт 27 ширхэг– төсөвт өртөг 936,949 төгрөг

Багц 2: Жирэмслэхээс сэргийлэх тариа 654 флакон– төсөвт өртөг 2,522,040 төгрөг

Багц 3: Жирэмслэхээс сэргийлэх хавсарсан дааврын эм нийт 1517 ширхэг– төсөвт өртөг 4,550,273 төгрөг

Багц 4: Эрэгтэй бэлгэвч нийт 3425 ширхэг– төсөвт өртөг 650,659 төгрөг

Багц 5: Яаралтай ууж жирэмслэхээс хамгаалах эм 22 ширхэг– төсөвт өртөг 69,404 төгрөг

Багц 6: Жирэмсний сорил нийт 47 ширхэг– төсөвт өртөг 70,961 төгрөг

Багц 7: Охидын ерөндөг нийт 9 ширхэг– төсөвт өртөг 47,715 төгрөг

Үнийн санал ирүүлэх ажлын зураг , техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг <http://www.bnemn.ub.gov.mn/> хаягаас авна уу.

Тендерийг 2019 оны 07 -р сарын 31 -ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн захиргаа, 103 тоот, Эдийн засагч Д.Мөнгөнцацрал хаягаар ирүүлнэ.

Нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 07 -р сарын 31-ны өдрийн 11 цаг 30 минут -т нээнэ.

- Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: Эрхгүй
- Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн захиргаа, 103 тоот,

Эдийн засагч Д.Мөнгөнцацрал

Утас -70213663, 70210238, 95096290

Шуудангийн хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, Эрүүл мэндийн төв

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|-------------------------|---|
| ТӨӨЗ 1.1 | <ul style="list-style-type: none"> - Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар /нотариатаар баталгаажуулсан/ - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл - Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; - Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ - Гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл /2-оос доошгүй хүний/ - Гэрээг гүйцэтгэхэд эргэлтийн хөрөнгө хүрэлцээтэй эсэхийг нотолсон бичиг баримт (үүнд зээл авах, тендерийн хүчинтэй хугацаан дахь дансны хуулга болон санхүүгийн бусад эх үүсвэрийн боломжийг оролцуулж болно) - Захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл - Одоогийн ба сүүлийн 2 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл - Гэрээний үнийн 10-аас дээш хувьтай тэнцэх дүнтэй ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүний чадварын талаарх мэдээллийг мөн адил бүрэн ирүүлнэ - Тендерт оролцогч гэрээний дагуу нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардлагад нийцэх тухай нотлох баримтуудыг тендерийн хамт ирүүлнэ - Нийлүүлэх барааны техникийн болон ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт болон барааны нөөцийг гэрчлэх зураг, үлдэгдлийн мэдээллийг баталгаажуулан ирүүлнэ - Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн тухай мэдэгдэл - Нийлүүлэх барааны чанар, стандартыг нотолсон эрх бүхий байгууллагаас олгосон сертификат - Барааны үнийн саналыг маягтын дагуу бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ - Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ - Харьяа дүүргийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн өргүй тухай тодорхойлолт ирүүлнэ - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас тодорхойлолт ирүүлнэ - Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай тодорхойлолт ирүүлнэ. /Улсын бүртгэлийн |

| | |
|------------------------|--|
| | <p>гэрчилгээнд заасан банк тус бүрээр/</p> <ul style="list-style-type: none"> - Тендерийн баримт бичгийн 5, 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ - Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтааж бараа захиалагчид нийлүүлэх баталгаа бичгээр ирүүлнэ - Нийлүүлэх барааг техникийн тодорхойлолтод нийцэж буйг нотлох баримт болгож тендерийн нээлтээс өмнө барааны дээжийг битүүмжлэн ирүүлнэ - Барааг нийлүүлсний дараах барааны баталгаа: Гэмтсэн, задарсан, хэрэглэх боломжгүй болсон барааг түргэн шуурхай сольж өгөх талаар мэдэгдэл <p>Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг гэрээ байгуулагдсан өдрийн маргааш бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд хүргэх үүрэгтэй.</p> |
| <p>ТӨӨЗ 2.1</p> | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Уг тендер нь тендер шалгаруулалтын харьцуулалтын аргыг ашиглан зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн захиргаа, 103 тоот хаягаар тендерийн материалаа цаасан хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Тендерийн материалд оролцогч байгууллага өөрийн хаяг, холбоо барих утас, оролцож буй тендерийн дугаарыг тодорхой бичсэн байна.</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хотын Багануур дүүрэг, 1-р хороо, Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн захиргаа, 103 тоот, Утас: 70213663, 70210238, 95096290</p> <p>Огноо: 2019 оны 07 дугаар сарын 31-ны өдөрЦаг: 11 цаг 00 минут</p> |
| <p>ТӨӨЗ 2.1</p> | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 1-р хороо, Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Эрүүл мэндийн төвийн захиргаа, Хурлын танхимд</p> <p>Огноо: 2019 оны 07 дугаар сарын 31-ны өдөр Цаг: 11 цаг 30 минут</p> |
| <p>ТӨӨЗ 6.2</p> | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: БНДЭМТ/201907-02;</p> <p>Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгсэл нийлүүлэх 7 багц</p> |

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

| № | Жирэмслэхээс сэргийлэх аргын нэр | Эмийн олон улсын нэр | Найрлага, эмийн хэлбэр | Савлалт | Техникийн үзүүлэлт |
|---|----------------------------------|---|--|---|--|
| 1 | Жирэмслэхээс сэргийлэх суулгац | Левоноргестрол эсвэл Этинилэстрадиол | Левоноргестрол эсвэл Этинилэстрадиол 75 мг нийлбэр, 150мг 3-5 жилийн хамгаалалт бүхий жирэмслэхээс сэргийлэх суулгац | Ширхэг, хөтлөгчтэй, уутанд савласан суулгац | |
| 2 | Жирэмслэхээс сэргийлэх тариа | Медроксипрогестрон | 50мг/мл-150мг Хүсээгүй жирэмслэлтээс 2-3 сарыг хамгаалахад зориулагдсан тарилга | Туншил эсвэл зүүтэй уутанцар бүхий тарилга | |
| 3 | Хавсарсан дааврын эм | Левоноргестрол+этинилэстрадиол Левоноргестрол+этинилэстрадиол+феррум Левоноргестрол+дроспиренон Этинилэстрадиол валерат+Левоноргестрол Дезогестерол+этинилэстрадиол Этинилэстрадиол+ципротероны ацетат Норгестрел +этинилэстрадиол Этинилэстрадиол + дроспиренон | Левоноргестрол 0,15 мг + этинилэстрадиол 0.02мг-0.04мг шахмал Левоноргестрол 0,15 мг + этинилэстрадиол 0.02мг-0.04мг +феррум50-100мг Левоноргестрол 0,15мг+дроспиренон 20мкг+30мкг Этинилэстрадиол валерат 2мг+ Левоноргестрол 0,15мг Дезогестерол 150мкг+этинилэстрадиол 20мкг-30мкг Этинилэстрадиол 20мкг-30мкг +ципротероны ацетат2мг Норгестрел + этинилэстрадиол Дроспиренон 3мг+Этинилэстрадиол 20мкг+30мкг | 28-30 хоногийн мөчлөг бүхий блистер /бүрхүүлтэй шахмал/ | 1. МУ-ын эмийн бүртгэлд бүртгэгдсэн байх 2. ДЭМБ-ын эсвэл НҮБХАС-н урьдчилсан баталгаажуулалтанд хамрагдсан байх 3. Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон байх 4. Эмийн үйлдвэрлэлийн зохицол дадал /GMP/-ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. |
| 4 | Яаралтай ууж сэргийлэх эм | Левоноргестрол | Левоноргестрол 0,75 мг*2 шахмал эсвэл Левоноргестрол 1,5мг | Нэг эсвэл хоёр шахмал агуулсан савлагаатай | |
| 5 | Эрэгтэй бэлгэвч | Эрэгтэй бэлгэвч | Эрэгтэй бэлгэвч 50-52 мм, стандарт, чийгшүүлэгчтэй | ширхэг | 1. ДЭМБ-ын эсвэл НҮБХАС-н урьдчилсан баталгаажуулалтын |

| | | | | | |
|---|-----------------|-----------------|---|-------------------------------------|---|
| 6 | Охидын ерөндөг | Охидын ерөндөг | Охидын ерөндөг IUD Cu375 | Ширхэг, хөтлөгчтэй, уутанд савласан | шаардлага хангасан хатуу зохицуулалттай орнуудад үйлдвэрлэсэн байх |
| 7 | Жирэмсний сорил | Жирэмсний сорил | Шээсэнд HCG тодорхойлох түргэвчилсэн тест | Нэг сорил агуулсан савлагаатай | <ol style="list-style-type: none"> 2. ISO-ийн шаардлага хангасан байх 3. Ердийн нөхцөлд хадгаладаг байх |

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| Нэр | Тодорхой лолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|--|--|------------|-------------|--|---|----------------------------------|--------------------------------------|
| | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Тариа | Тариа | 654 | ш | БНД ЭМТ | Гэрээ хийсний маргааш | Гэрээ хийснээс 14 хоногийн дотор | |
| Суулгац | Суулгац | 27 | ш | БНД ЭМТ | Гэрээ хийсний маргааш | Гэрээ хийснээс 14 хоногийн дотор | |
| Хавсарсан дааврын эм | Хавсарсан дааврын эм | 1517 | ш | БНД ЭМТ | Гэрээ хийсний маргааш | Гэрээ хийснээс 14 хоногийн дотор | |
| Яаралтай ууж жирэмслэхээс хамгаалах эм | Яаралтай ууж жирэмслэхээс хамгаалах эм | 22 | ш | БНД ЭМТ | Гэрээ хийсний маргааш | Гэрээ хийснээс 14 хоногийн дотор | |
| Эрэгтэй бэлгэвч | Эрэгтэй бэлгэвч | 3425 | ш | БНД ЭМТ | Гэрээ хийсний маргааш | Гэрээ хийснээс 14 хоногийн дотор | |
| Охидын ерөндөг | Охидын ерөндөг | 9 | ш | БНД ЭМТ | Гэрээ хийсний маргааш | Гэрээ хийснээс 14 хоногийн дотор | |
| Жирэмсний сорил | Жирэмсний сорил | 47 | ш | БНД ЭМТ | Гэрээ хийсний маргааш | Гэрээ хийснээс 14 хоногийн дотор | |

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]